



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1076

танай _____ -ны № _____ -т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Эрх чөлөөний эвсэл нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Эрх чөлөөний эвсэл нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Эрх чөлөөний эвсэл нам"-ын мөрийн хөтөлбөр /.....².....хуудас-ийг хавсаргав.


МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030681

ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭВСЭЛ Намын Сенатын
2024 оны 03 дугаар сарын 24-ний
өдрийн N°02 тогтоолын хавсралт N°01



ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭВСЭЛ нам
МӨРИЙН ХӨТӨЛБӨР- 2024

“Хувь хүний эрх чөлөө - Хязгаарлагдмал төр”



00000001

Ерөнхий зүйл

Монгол улсын үндсэн хууль, Эрх Чөлөөний Эвсэл намын Баруун жигүүрийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжуудыг үндэслэл болгон мөрийн хөтөлбөрөө боловсруулав.



НЭГ.

Эрх Чөлөөний Эвсэл нам хуулийн хүрээнд Баруун жигүүрийн үзэл баримтлалтай иргэдийн дуу хоолой болж ажиллана.


ХОЁР.

Эрх Чөлөөний Эвсэл нам Улсын Их Хурлаар батлагдах аливаа хууль тогтоомжуудад хяналт тавьж, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

ГУРАВ.

Эрх Чөлөөний Эвсэл нам нь хувь хүний эрх чөлөө, хувийн өмч, чөлөөт зах зээл, эдийн засгийн эрх чөлөө, чөлөөт өрсөлдөөнийг тууштай баримталж чинээлэг иргэдтэй, хараат бус бие даасан Монгол улсыг бэхжүүлнэ. Баруун жигүүрийн үзэл баримтлалыг баримтлан

- Хувь хүний эрх чөлөө
- Хувийн өмч, өмчлөх эрх
- Чөлөөт зах зээл
- Хязгаарлагдмал төр, цомхон засаг
- Эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах
- Чөлөөт өрсөлдөөн, эдийн засгийн эрх чөлөө, улс төрийн эрх чөлөө
- Тэгшитгэх үзлийн эсрэг
- Дабль стандартгүй хуулийн өмнө хүн бүр эрх тэгш
- Дарангуйлал, түрэмгийллийн эсрэг
- Оюун санааны эрх чөлөө, шинжлэх ухааны мэдлэг, туршлагыг хүндэтгэсэн
- Өнгөрсөн - Өнөө - Ирээдүй гурван цагийн хэлхээс, уламжлал
- Хараат бус, бие даасан, эрх чөлөөт Монгол улс гэсэн агуулгаар хуулийн төслүүд боловсруулан хэлэлцүүлнэ. (Энэ нь ямар нэг санхүүгийн эх үүсвэр шаардахгүй бөгөөд зөвхөн нээлттэй санал асуулга, хэлэлцүүлгийн хүрээнд хийгдэх ажил болно.)



00000002